



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 10/32

Улаанбаатар хот

Гадаадад томилолтоор ажиллуулах  
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 4.7.6, 4.7.8 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны А/59 дүгээр тушаалаар батлагдсан Иргэний нисэхийн ерөнхий газраас гадаадад албан томилолтоор ажиллуулах болон сургалтад хамруулах журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгд Найрамдах Казакстан Улсын Алма-Ата хотноо 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Хүннү Эйр ХХК нь Улаанбаатар-Ховд-Алма-Ата, Улаанбаатар-Ховд-Нурсултан чиглэлд хуваарьт нислэгийн шинэ шугам нээж байгаатай холбогдуулан хийгдэх уулзалтад Агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Г.Батбаяр, Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газрын дарга Ч.Одгэрэл, ИНҮТ-ийн Олон нийттэй харилцах хэсгийн мэргэжилтэн Ч.Энхжаргал нарыг томилон ажиллуулсугай.

2. Гадаадад томилолтоор ажилласан тухай тайланг ажлын 5 хоногийн дотор удирдлагад танилцуулахыг Г.Батбаяр, Ч.Одгэрэл, Ч.Энхжаргал нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

С.МӨНХНАСАН